

Sinocare

iCan™ i3

CGM Хэрэглэгчийн
гарын авлага



ГАРЧИГ

ХУУЛЬ ЁСНЫ ТАТГАЛЗАЛ	1
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ	2
iCan Health сахарын тогтмол хяналтын (CGM) системийг ажиллуулж эхлэх	3
Эх үүсвэр	4
1-р хэсэг: Системийн тойм	6
1.1 Системийн тайлбар	7
1.2 Төлөвлөсөн зорилго.....	9
1.3 Хэрэглэгчийн аюулгүй байдал	10
2-р хэсэг: Мэдрэгчээ ажиллуулж эхлэх	19
2.1 Мэдрэгч бэлтгэх	20
2.2 Хэсэг сонгох	25
2.3 Мэдрэгчээ дамжуулагчтай холбох.....	26
2.4 Мэдрэгчийг хэрэглэх.....	28
2.5 Мэдрэгч халаах.....	33
3-р хэсэг: iCan i3 CGM-ийн үр дүн	35
3.1 Үндсэн дэлгэцийн тойм	36
3.2 Сахарын хэмжээний мэдээлэл	36
3.3 Чиглүүлэх ба төлөвийн самбар.....	41
3.4 Үйл явдал	42
3.5 Дохиолол	44

3.6 Нэвтрэх	51
4-р хэсэг: Эмчилгээний шийдвэр	54
4.1 Эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэйгээ (ЭМҮТ) ярилцах	55
4.2 Цусан дахь сахар хэмжигчийг хэзээ хэрэглэх вэ	55
4.3 Эмчилгээний шийдвэр гаргахдаа CGM-ийг хэрэглэх	55
5-р хэсэг: Үзлэг дуусгах	57
5.1 Мэдрэгчийн үзлэгийг дуусгах	58
5.2 Мэдрэгчийг салгах	59
5.3 Шинэ мэдрэгчийн үзлэгийг эхлэх	59
A хавсралт: Эвдрэл гэмтлийг олох	60
B хавсралт: Аюулгүй байдал ба агаарын аялал	64
C хавсралт: CGM-ыг хэрхэн хийх тухай	65
D хавсралт: Техникийн мэдээлэл	69
E хавсралт: Шошгоны тэмдгүүд	78
F хавсралт: Чичиргээ болон дохиоллын дуу	81
Тайлбар толь	87

ХУУЛЬ ЁСНЫ ТАТГАЛЗАЛ

©2024 Sinocare Inc. Sinocare iCan нь Sinocare Inc. компанийн худалдааны тэмдэг юм. АНУ болон Олон улсын патент хүлээгдэж байна. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Бүх барааны тэмдэг, зохиогчийн эрх тус тусын эзэмшигчийн өмч юм.

Bluetooth® үгийн тэмдэг, лого Bluetooth SIG, Inc компанийн эзэмшдэг бүртгэлтэй худалдааны тэмдгүүд бөгөөд Sinocare Inc компани тухайн тэмдгийг ашиглах зөвшөөрөлтэй. Бусад барааны тэмдэг, худалдааны нэр тус тусын эзэмшигчдээ хамаарна.

Apple, Apple лого, iPhone болон iPod touch бол АНУ болон бусад улсад бүртгэлтэй Apple Inc компанийн худалдааны тэмдэг. APP Store бол Apple Inc. компанийн үйлчилгээний тэмдэг.

Android бол Google ХХК-ийн худалдааны тэмдэг. Google Play ба Google Play лого бол Google ХХК-ийн худалдааны тэмдэг.

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

iCan i3 сахарын тогтмол хяналтын (CGM) системийг хэрэглэхийн өмнө хэрэглэх зааварт багтсан зааврыг уншина уу. Хэрэглэх заавар аюулгүй байдлын чухал мэдээлэл, хэрэглэх заавар агуулдаг. Чихрийн шижин өвчнийг зохицуулахад туслахын тулд iCan i3 CGM-ийн мэдээллийг хэрхэн хэрэглэх талаар эрүүл мэндийн мэргэжилтэнтэйгээ ярилцана уу.

iCan i3 CGM систем болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэглэх заавар, бүх заалт, эсрэг заалт, сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, анхааруулгын дагуу хэрэглэхгүй байх нь хүнд хэлбэрийн гипогликеми (цусан дахь сахарын хэмжээ багасах) эсвэл гипергликеми (цусан дахь сахарын хэмжээ ихсэх) өвчнийг анзаарахгүйбайх ба/эсвэл гэмтэл учруулж болох эмчилгээний шийдвэр гаргахад хүргэж болзошгүй. Хэрэв iCan i3 CGM-ийн хариу таны шинж тэмдэг, хүлээлттэй тохирохгүй байвал цусан дахь сахар хэмжигчээс авсан цусан дахь сахарын (BG) утгыг ашиглан чихрийн шижин өвчний эмчилгээний шийдвэр гаргана уу. Тохиромжтой үед эмнэлгийн тусламж аваарай.

iCan i3 CGM-тай холбоотой гарсан аливаа ноцтой ослыг Sinocare болон таны байгаа гишүүн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой.

iCan Health сахарын тогтмол хяналтын (CGM) системийг ажиллуулж эхлэх

Сахарын тогтмол хяналтын систем (цаашид CGM гэх) цусан дахь сахарын (BG) хэмжээг хянахаас илүүтэйгээр сахарын хяналтыг бүрэн харах боломж олгодог. Мэдрэгчийг ашигласнаар 24 цаг тутамд 480 хүртэлх сахар мэдрэгчийн (SG) заалтыг хүлээн авч, цусан дахь сахарын хяналт хоорондын зайг нөхөх боломжтой. CGM дохиолол танд сахарын хэмжээ өндөр ба бага байгааг мэдэгдэнэ.

График болон чиглэл заасан өөрчлөлтийн сумнууд таны сахарын түвшин хөдөлж буй хурд, чиглэлийг харуулна.

Энэхүү хэрэглэх зааврыг (мөн хэрэглэгчийн гарын авлага гэж нэрлэдэг) iCan Health сахарын тогтмол хяналтын (CGM) системийн тохиргоо, үйл ажиллагааг ойлгоход тань туслах зорилготой. Танд хэрэгтэй мэдээллээ олоход туслахын тулд хэрэглэгчийн гарын авлагын эхэнд байгаа гарчиг, хэрэглэгчийн гарын авлагын төгсгөлд байгаа индексийг хэрэглэж болно. Мөн хэрэглэгчийн гарын авлагын төгсгөлд нэр томъёоны тайлбар толь бий.

Дараах хүснэгтэд энэхүү хэрэглэгчийн гарын авлагад ашигласан тодорхой нэр томъёо, тогтсон журам, ойлголтуудыг тайлбарласан болно.

Тогтсон журам	Тайлбар
Тэмдэглэл	Нэмэлт хэрэгтэй мэдээлэл өгнө.
СЭРЭМЖЛҮҮЛЭГ	Хэрэв зайлсхийхгүй бол бага, дунд зэргийн гэмтэл, тоног төхөөрөмжид гэмтэл учруулж болзошгүй аюулын талаар танд мэдэгдэнэ.
АНХААРУУЛГА	Хэрэв зайлсхийхгүй бол амь насаа алдах эсвэл ноцтой гэмтэл учруулж болзошгүй аюулын талаар танд мэдэгдэнэ. Мөн энэ нь болзошгүй ноцтой сөрөг урвал, аюулгүй байдалд учирч болох аюулын талаар тайлбарлана.
Тод текст	Дэлгэцийн зүйлс, товчлууруудыг заана. Жишээлбэл, "Үргэлжлүүлэхийн тулд дараах гэснийг сонгоно уу"

Эх үүсвэр

Зааварчилгаа:

Манай зааварчилгаа танд дэлгэцийн төхөөрөмж сонгох, мэдрэгч оруулах, дохиолол ашиглах зэрэг мэдрэгчийн анхны үзлэг хийх талаар зааж өгнө.

Зааварчилгааг iCan-cgm.com вебсайтаас үзэх боломжтой

Апп доторх видеонууд:

Танд сурахад туслах апп доторх видеонууд бий:

- **Тойм:** Таны CGM-ийн сахар мэдрэгч одоо хаана байгаа, хаашаа чиглэж байгаа, хаана байгааг хэрхэн харуулж байгааг хараарай
- **Мэдрэгч оруулах:** Мэдрэгчээ оруулах талаарх заавар

Та эдгээр видеог апп-аа тохируулж байхдаа эсвэл хүссэн үедээ

Тохиргоо > Тусламж > Видео хэсгээс үзэх боломжтой.

Гарын авлага:

- **Түргэн эхлэх гарын авлага:** танд дэлгэцийн төхөөрөмжөө тохируулах, мэдрэгчээ оруулах, мэдрэгчийн анхны үзлэг эхлүүлэхэд тусална. Та үүнийг iCan хайрцгаас олох боломжтой.
- **Хэрэглэх заавар (Хэрэглэгчийн гарын авлага):** Энэ хэрэглэгчийн гарын авлага бол таны нэвтэрхий толь. Энэ нь танд iCan системийн хамгийн өргөн хүрээг хамарсан тойм, онцлог шинж чанарууд, аюулгүй байдлын чухал мэдээлэл, бусад олон зүйлийг өгнө.

Та тус хоёр гарын авлагыг татаж авах эсвэл хэвлэсэн хувилбарыг авах боломжтой: PDF файлыг iCan-cgm.com вебсайтаас татаж авна уу

Үнэгүй хувийг дараах имэйл хаягаар авна уу: iCansupport@sinocare.com

Sinocare тусламж авах Хэрэглэгчийн тусламж үйлчилгээний имэйлийг өгдөг. Хэрэв танд асуудал гарвал iCansupport@sinocare.com хаягаар мэдэгдэнэ үү. Хүсэлт илгээхдээ та имэйлдээ төхөөрөмжийн серийн дугаар байгаа эсэхийг шалгана уу. Серийн дугаарыг таны мэдрэгчийн багцын савлагаа дээр бичсэн байдаг.

Холбоо барих мэдээлэл	
Хэрэглэгчийн тусламж үйлчилгээний имэйл	iCansupport@sinocare.com
Вебсайт	iCan-cgm.com

1-р хэсэг: Системийн тойм

- Системийн тайлбар
- Төлөвлөсөн зорилго
- Хэрэглэгчийн аюулгүй байдал

1.1 Системийн тайлбар




iCan i3 Сахарын тогтмол хяналтын системийг (цаашид CGM гэх) сонгосон танд баярлалаа. iCan i3 CGM систем Мэдрэгчийн багц, Bluetooth-р ажилладаг эрчим хүчний хэмнэлттэй (BLE) дамжуулагчийн багц, гар утасны аппликэйшн (APP) гэсэн гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

iCan i3 CGM сахарын түвшинг бодит цагийн горимоор хангаж, танд сонгосон хөдөлгөөнт төхөөрөмж дээрээ сахар мэдрэгчийн заалтыг тасралтгүй харах боломж олгоно. Энэхүү систем завсрын шингэн дэх сахарын хэмжээг хэмжих замаар 3 минут тутамд таны сахарыг хянана. Таны арьсанд оруулсан мэдрэгч сахарын үр дүнг дамжуулагч руу, дамжуулагч сахарын үр дүнг iCan Health сахарын тогтмол хяналтын системийн APP (CGM APP) руу илгээдэг. Дараа нь APP таны сахарын түвшин, урт хугацааны сахарын өөрчлөлтийг харуулдаг. APP таны сахар аюултай бүсэд байгаа эсвэл байх төлөвтэй тохиолдолд дохиолол өгдөг.

iCan i3 CGM өөрчлөлт, хяналтын хэв маягийг тогтоож, гипергликеми, гипогликемийн үеийг илрүүлэхэд тусалж, цочмог болон урт хугацааны эмчилгээний тохируулгыг хялбарчилдаг. Системийн үр дүнгийн тайлбар сахарын өөрчлөлт, цаг хугацааны хэд хэдэн дараалсан үр дүнд суурилсан байх ёстой.

Тэмдэглэл: Системийг ашиглахаас өмнө энэ зааварт заасан бүх зааврыг уншина уу.

1.1.1 Төхөөрөмжийн бүрэлдэхүүн хэсгүүд

Таны юу олж харарх вэ	Үүнийг юу гэж нэрлэдэг вэ	Энэ яаж ажилладаг вэ
	Мэдрэгчийн багц	Энэ бол мэдрэгчийг хадгалдаг ариутгасан савлагаа. Мэдрэгч багц нэг удаагийн хэрэглээнд зориулагдсан.
	Мэдрэгч - Аппликатор	<p>Мэдрэгч - Аппликатор мэдрэгчийг арьсан доор оруулахад тусална. Энэ нь мэдрэгчийн уян үзүүрийг арьсанд нэвтрүүлэхийн тулд арьс цоолоход хэрэглэдэг зүүтэй боловч мэдрэгчийг байрлуулсны дараа канистр руу буцааж татна. Тиймээс зүү үлдэхгүй. Мэдрэгчийг 15 хүртэл хоног зүүж болно.</p> <p>Мэдрэгчийг хэрхэн хэрэглэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2-р бүлгээс үзнэ үү.</p>
	Дамжуулагчийн багц	<p>Дамжуулагчийг мэдрэгч рүү залгаж, бодит цагийн сахарын заалтыг таны тохирох дэлгэцийн төхөөрөмж рүү Bluetooth ашиглан утасгүйгээр илгээнэ. Та үүнийг хэрэглэхдээ дамжуулагчийг тавиураас гаргах шаардлагагүй.</p> <p>Дамжуулагчаа хэрхэн хэрэглэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 2-р бүлгээс үзнэ үү.</p>

1.1.2 iCan Health CGM APP



iCan Health CGM APP нь iCan i3 CGM-ийн дэлгэцийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Android, iOS төхөөрөмжүүдэд (хөдөлгөөнт төхөөрөмж) ажилладаг. Тус APP Google Play (Android), APP Store (iOS)-т байдаг. Тохиромжтой хөдөлгөөнт төхөөрөмжүүдийн жагсаалтыг харахын тулд iCan-cgm.com вебсайтыг үзнэ үү

АНХААРУУЛГА: iCan Health CGM APP-аас дохиолол ирэхгүй байснаар сахарын хэмжээ тодорхойгүй бага, өндөр байж болзошгүй. Зориулалтын дагуу дохиолол хүлээн авахын тулд энэхүү хэрэглэх зааварт заасан заавар, аюулгүй байдлын анхааруулгыг дагаж мөрдөөрэй.

1.2 Төлөвлөсөн зорилго

Сахарын тогтмол хяналтын систем бол насанд хүрсэн хүмүүсийн (18 ба түүнээс дээш насны) чихрийн шижин өвчнийг эмчлэхэд зориулсан бодит цаг хугацаанд ажилладаг, сахарын тогтмол хяналтын төхөөрөмж юм. Энэ нь чихрийн шижин өвчний эмчилгээний шийдвэр гаргахад хурууны өндөгний цуснаас авах сахарын шинжилгээг орлуулах зорилготой. CGM өөрчлөлт, хяналтын хэв маягийг тогтоож, гипергликеми, гипогликемийн үеийг илрүүлэхэд тусалж, цочмог болон урт хугацааны эмчилгээний тохируулгыг хялбарчилдаг. Системийн үр дүнгийн тайлбар сахарын өөрчлөлт, цаг хугацааны хэд хэдэн дараалсан үр дүнд суурилсан байх ёстой.

CGM-ийг хэрэглэгч эмчилгээний шийдвэр гаргах үйлдлийг гараар хянада ухаалаг төхөөрөмжтэй хамт хэрэглэх боломжтой.

1.3 Хэрэглэгчийн аюулгүй байдал

Энэ хэсэг заалт, эсрэг заалт, аюулгүй байдлын анхааруулга, болзошгүй сөрөг урвал, мөн цацрагийн нөлөөллөөс системээ гэмтээхээс хэрхэн хамгаалах зэрэг аюулгүй байдлын чухал мэдээлэл агуулдаг.

1.3.1 Эсрэг заалт

- Хэрэв та жирэмсэн, диализийн аппарат хэрэглэдэг, зүрхний аппарат суулгасан эсвэл хүнд өвчтэй бол iCan i3 CGM-ийг хэрэглэж болохгүй. Эдгээр бүлэгт түгээмэл тохиолддог янз бүрийн нөхцөл байдал эсвэл хэрэглэдэг эмүүд системд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байна. Эдгээр бүлэгт iCan i3 CGM-ийн үр дүн үнэн зөв гарахгүй байж магадгүй.
- MRI/CT/диатерми байхгүй
iCan i3 CGM (мэдрэгч, дамжуулагч, хүлээн авагч эсвэл хөдөлгөөнт төхөөрөмж)-ийг соронзон резонансын дүрслэл (MRI), компьютер томографийн (CT) сканнер эсвэл өндөр давтамжийн цахилгаан дулаан (диатерми) эмчилгээнд орохдоо зүүж болохгүй. Эдгээр нөхцөлд iCan i3 CGM-ийг туршиж үзээгүй. Соронзон орон ба дулаан iCan i3 CGM-ийн бүрэлдэхүүн хэсгүүдийг гэмтээж болох бөгөөд энэ нь сахар мэдрэгчийн заалтын үр дүн буруу харуулах эсвэл дохиолол өгөхгүй болгож болзошгүй. iCan i3 CGM-ийн заалтын үр дүн эсвэл дохиоллын мэдэгдэл ирэхгүй бол та сахарын хэмжээ огцом бага эсвэл өндөр болох явцыг мэдэхгүй байж болзошгүй.

Бид танд үзлэгээ хамгийн их сайн үр дүнд хүргэхийн тулд нэмэлт мэдрэгч ашиглахаас зайлсхийхийн тулд мэдрэгчийн үзлэгийн төгсгөлд процедурыг төлөвлөхийг зөвлөж байна. Эмнэлгийн бусад процедурын талаар зөвлөгөө авахын тулд эмчдээ үзүүлнэ үү.

Та процедурт орохдоо цусан дахь сахарын хэмжигчээ авч яваарай.



MR АЮУЛГҮЙ БУС

- Хэрэв та цус бүлэгнэлтийн эмгэгтэй эсвэл цусны бүлэгнэлтийн эсрэг эм хэрэглэж байгаа бол iCan i3 CGM-ийг хэрэглэж болохгүй.

1.3.2 Аюулгүй байдлын анхааруулга

1.3.2.1 Ерөнхий анхааруулга

АНХААРУУЛГА:

- Сахар Бага/Өндөр болох шинж тэмдгийг тоохгүй орхиж болохгүй
Цусан дахь сахар бага эсвэл өндөр болсонтой холбоотой шинж тэмдгүүдийг үл тоомсорлож болохгүй. Цусан дахь сахар хэмжигчээ өөрт ойр байлгаарай. Хэрэв танд сахар мэдрэгчийн заалтын үр дүнтэй тохирохгүй шинж тэмдэг илэрвэл эсвэл таны үр дүн буруу байна гэж сэжиглэж байвал цусан дахь сахар

хэмжигч ашиглан хурууны өндөгний шинжилгээ хийж, үр дүнг шалгана уу. Хэрэв таны сахарын заалтын үр дүнтэй тохирохгүй шинж тэмдэг илэрвэл эрүүл мэндийн мэргэжилтэндээ үзүүлнэ үү.

- Хэрэв эмчилгээний шийдвэр байхгүй бол....

Хэрэв таны iCan i3 CGM-д тоо эсвэл сум харагдахгүй эсвэл таны үр дүн таны шинж тэмдгүүдтэй тохирохгүй байвал чихрийн шижингийн эмчилгээний шийдвэр гаргахын тулд цусан дахь сахар хэмжигчээ хэрэглэнэ үү.

- Өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй.

Өвчтөн бол төлөвлөсөн оператор юм. Энэ тоног төхөөрөмжид өөрчлөлт хийхийг

зөвшөөрөхгүй.

- Хэрэглэж болохгүй тохиолдлууд....

АНХААРУУЛГА: Хэрэв та жирэмсэн, диализийн аппарат хэрэглэдэг, зүрхний аппарат суулгасан эсвэл хүнд өвчтэй бол iCan i3 CGM-ийг хэрэглэж болохгүй. Эдгээр бүлэгт түгээмэл тохиолддог янз бүрийн нөхцөл байдал эсвэл хэрэглэдэг эмүүд системд хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй байна. Эдгээр бүлэгт iCan i3 CGM-ийн үр дүн үнэн зөв гарахгүй байж магадгүй.

1.3.2.2 APP ба хөдөлгөөнт төхөөрөмж

- Та шинэ мэдрэгч асаах үед мэдрэгчийг халаах 2 цагийн хугацаанд CGM-ийн үр дүн эсвэл дохиолол хүлээж авахгүй. Чихрийн шижин өвчний эмчилгээний шийдвэр гаргахын тулд цусан дахь сахар хэмжигч хэрэглэнэ үү.
- Таны хөдөлгөөнт төхөөрөмж Нислэгийн горимд байсан ч Bluetooth асаалттай байгаа эсэхийг шалгаарай. Хэрэв Bluetooth унтраалттай бол та сахар мэдрэгчийн мэдээлэл эсвэл дохиолол хүлээж авахгүй.

- Хэрэв таны гар утасны дэлгэц эсвэл чанга яригч гэмтсэн бол iCan Health CGM APP-г хэрэглэж болохгүй. Хэрэв таны хөдөлгөөнт төхөөрөмж гэмтсэн эсвэл алдагдсан бол та сахар мэдрэгчийн дохиоллыг хүлээж авахгүй, сахар мэдрэгчийн мэдээлэл зөв харагдахгүй байж магадгүй.
- Чихэвч холбосон үед iCan Health CGM APP-н дохиолол таны чихэвчинд сонсогдоно. Хэрэв та чихэвчээ хэрэглээгүй үедээ холбосон бол сахар мэдрэгчийн дохиоллыг сонсохгүй байж магадгүй.
- Хэрэв таны хөдөлгөөнт төхөөрөмж дахин асвал iCan Health CGM APP автоматаар дахин асахгүй байж магадгүй. Хэрэв та APP-г дахин нээхгүй бол сахар мэдрэгчийн дохиоллыг авахгүй байж магадгүй. Хөдөлгөөнт төхөөрөмжөө дахин эхлүүлсний дараа APP-г нээхээ мартуузай.

1.3.2.3 Дамжуулагч

- Хэрэв та дамжуулагч цуурсан, хагарсан, гэмтсэнийг харсан бол төхөөрөмжийг хэрэглэж болохгүй. Гэмтсэн дамжуулагч цахилгаан гүйдлээс болж гэмтэл учруулж, iCan i3 CGM-ийг зохих байдлаар ажиллахгүй болгож болзошгүй.
- Хүүхэд, тэжээвэр амьтдыг жижиг хэсгүүдийг амандаа хийхийг зөвшөөрч болохгүй. Энэ бүтээгдэхүүнээс болж бага насны хүүхэд, тэжээвэр амьтад хахах аюултай.
- Системийн хэвийн ажиллагаанд саад учруулж болзошгүй бусад цахилгаан тоног төхөөрөмжийн хажууд дамжуулагчийг хэрэглэж болохгүй. Системийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй бусад цахилгаан тоног төхөөрөмжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг D хавсралтаас үзнэ үү.
- Дамжуулагчийг шатамхай мэдээ алдуулагч бодис, тэсэрч дэлбэрэх хий байгаа газарт ажиллуулж болохгүй.

- Дамжуулагчийг эмнэлгийн хог хаягдлын саванд хийж, хэт халуун газар хаяж болохгүй. Дамжуулагч гал авалцаж, гэмтэл учруулж болзошгүй батерейтай.

1.3.2.4 Мэдрэгч

- Мэдрэгчийн эвдэрсэн эсвэл салсан үзүүрийг тоохгүй оржих болохгүй. Мэдрэгчийн үзүүр арьсан доор үлдэж магадгүй. Хэрэв ийм зүйл тохиолдвол манай Хэрэглэгчийн тусламж үйлчилгээний имэйл эсвэл эрүүл мэндийн мэргэжилтэнтэйгээ холбогдоно уу. Хэрэв таны арьсан доорх мэдрэгчийн үзүүр тасарч, та үүнийг харахгүй бол түүнийг авах гэж оролдож болохгүй. Мэргэжлийн эмчээс тусламж хүсэх эсвэл манай Хэрэглэгчийн тусламж үйлчилгээний имэйлээр холбогдоно уу.
- iCan i3 CGM төхөөрөмжөө -г 2°C-аас 30°C-ийн температурт хадгална уу. Мэдрэгчийн багцыг хөлдөөгчид хийж болохгүй.
- Хугацаа нь дууссан мэдрэгчийг хэрэглэж болохгүй, учир нь заалтын үр дүн нь буруу гарч болзошгүй. Дуусах огноо нь элсэн цагны тэмдгийн хажууд байгаа мэдрэгчийн багцын шошгон дээрх ЖЖЖЖ-СС-ӨӨ (Жил-Сар-Өдөр) форматтай байна.
- Халдвар үүсгэж болзошгүй тул ариутгасан савлагаа нь гэмтсэн эсвэл нээгдсэн мэдрэгчийг хэрэглэж болохгүй.
- Ил гарсан мэдрэгч бохирдож болзошгүй тул мэдрэгчийг оруулахад бэлэн болтол ариутгасан савлагааг нээж болохгүй.
- Хаалтын аргууд эсвэл наалтууд хэрэглэх нь төхөөрөмжийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй. Хэрэв танд энэ мэдрэгчтэй холбоотой арьсны хариу урвал илэрсэн бол энэ төхөөрөмжийг үргэлжлүүлэн хэрэглэх эсэхээ эрүүл мэндийн мэргэжилтэнтэйгээ зөвлөлдөнө үү.

1.3.2.5 Цус алдах

- Мэдрэгчийг оруулахын тулд завсрын шингэнд хүрэхийн тулд цусны судаснуудад бүхэлд нь тархдаг зүү ашиглан арьсны дермисийн давхарга руу нэвтрэх ёстой.
- Эдгээр судсанд нэвтрэн орж байх үед зүүгээр цоолвол цус алдаж болзошгүй. Мэдрэгчийг биед хэт гүн оруулбал цус алдаж болзошгүй. Аппликатораар оруулахдаа хэт их дарж оруулахгүй байхад анхаарах хэрэгтэй.
- Хэрэв цус алдвал дараах зүйлийг хийнэ үү:
 - Ариутгасан самбай эсвэл мэдрэгчийн дээд талд байрлуулсан цэвэр даавууг ашиглан гурван минутын турш тогтвортой дарна.
 - Хэрэв цус алдалт зогсвол APP-г мэдрэгчид холбоно уу.
 - Хэрэв цус алдалт зогсохгүй бол мэдрэгчийг зайлуулж, ариутгасан самбайгаар цэвэрлэнэ. Цус алдах газраас дор хаяж 7 см (3 инч) зайд шинэ мэдрэгчийг өөр газар байрлуулна.

1.3.3 Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

1.3.3.1 Ерөнхий урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- iCan i3 CGM төхөөрөмждөө шавьж, нарнаас хамгаалах тос оруулахаас зайлсхий.
Эдгээр арьс арчилгааны бүтээгдэхүүнтэй харьцах нь таны CGM-д гэмтэл учруулж болзошгүй.
- iCan i3 CGM-ийг халуун усанд ороходоо зүүж болохгүй.
- Хэрэв таны мэдрэгчийнхээ эргэн тойронд эсвэл доорх арьс мэдэгдэхүйц чочирсныг анзаарсан бол мэдрэгчийг салгаад, CGM-ийг хэрэглэхээ зогсооно уу. CGM-ийг үргэлжлүүлэн хэрэглэхээсээ өмнө эрүүл мэндийн мэргэжилтэнтэйгээ холбогдоно уу.

- CGM систем нэг удаагийн хэрэглээнд зориулагдсан. Дахин хэрэглэснээр сахарын заалтын үр дүн гарахгүй байж, халдвар үүсгэж болзошгүй.
- Бүтээгдэхүүний хяналтын үр дүнг зөвхөн чихрийн шижин өвчний туслах оношлогооны лавлагаа болгон ашиглах боломжтой бөгөөд эмнэлзүйн оношлогооны үндэс биш юм.
- Хэрэв хорсож буй мэдрэмж, таагүй мэдрэмж төрвөл CGMS-ийг яаралтай салгана уу

1.3.3.2 Таны цусан дахь сахарын шинжилгээ

Завсрын шингэн дэх сахарын түвшин цусан дахь сахарын түвшнөөс өөр байж болох ба сахар мэдрэгчийн заалтын үр дүн цусан дахь сахарын өөр байна гэсэн үг юм. Цусан дахь сахар хурдан өөрчлөгдөж байгаа үед та энэ ялгааг анзаарч магадгүй. Жишээлбэл, хоол идсэний дараа, инсулин ууж, дасгал хийсний дараа. Хэрэв таны заалтын үр дүн буруу байж магадгүй гэж сэжиглэж байвал цусан дахь сахар хэмжигч ашиглан хурууны өндөгнөөс шинжилгээ хийж, үр дүнг шалгана уу.

1.3.3.3 Эхлэхээсээ өмнө бэлдэх

- Мэдрэгчээ оруулахаасаа өмнө гараа, оруулах хэсгээ цэвэрлэж, хатаана уу. Гараа гелэн цэвэрлэгчээр биш, савантай усаар угааж, мэдрэгчийн багцыг нээхээс өмнө хатаана уу. Мэдрэгчийг оруулах үед гар чинь бохир байвал оруулах хэсэгт нянгууд орж, халдвар авч болно.
- Халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд оруулах хэсгээ спирттэй хөвөнгөөр цэвэрлэ.

Арьс хатах хүртэл мэдрэгчийг оруулж болохгүй. Хэрэв таны оруулах хэсэг цэвэр, бүрэн хуурай биш бол та халдвар авах эсвэл дамжуулагч сайн наалдахгүй байх эрсдэлтэй.

- Арьсан дээрээ шавьж, нарнаас хамгаалах тос, үнэртэй ус, тос түрхээгүй байх хэрэгтэй.
- Оруулахын өмнө шалгах зүйлс:
 - Гартаа барьсан аппликаторыг арьсандаа наах хүртэл аюулгүй байдлын хамгаалалтыг түгжээтэй байлга. Хэрэв та түгжээг тайлахын тулд эхлээд хамгаалалтын хаалтыг авбал мэдрэгч оруулах товчлуурыг санамсаргүй байдлаар дарж өөрийгөө гэмтээж болно.
 - Мэдрэгч тус бүрийн оруулах хэсгийг өөрчил. Нэг хэсэгт хэт олон удаа оруулах нь арьсанд эдгэх боломж олгодоггүй бөгөөд энэ нь сорви үүсгэж, арьс цочроох шалтгаан болдог.
- Мэдрэгч байрлуулах хэсэг:
 - Инсулин шахах тарилгын багц эсвэл тарилгын хэсгээс багадаа 7 см (3 инч) зайд байх;
 - Бүсэлхий хэсэг, сорви, шивээс, цочирсон хэсэг, яснаас хол байх;
 - Унтаж байхдаа мөргөх, түлхэх, хэвтэх магадлал багатай байх

1.3.3.4 Мэдрэгч хэрэглэхтэй холбоотой болзошгүй эрсдэлүүд

- Хамгаалалтын хяналтын цэгээр дамжин өнгөрөх
 - iCan i3 CGM-ийг зүүж байхдаа Тээврийн аюулгүй байдлын захиргаанаас (TSA) мэдрэгч, дамжуулагчийн нүдэн үзлэг хийлгэх талаар ярилцаарай, биед тэмтэрч үзлэг хийхийг хүс. iCan i3 CGM системийн бүрэлдэхүүн хэсгүүдийг рентген аппаратанд хийж болохгүй. АIT их биеийн сканнер, рентген аппаратын үр нөлөөг үнэлээгүй эсвэл iCan i3 CGM-д үүсэж болзошгүй хохирлыг талаар мэдээлээгүй байна.

- Усанд орох, шүршүүрт орох, усанд сэлэх
 - Мэдрэгчийг усанд орох, шүршүүрт орох үед зүүж болох боловч халуун ваннд орж болохгүй, удаан хугацаанд халуунд байх нь мэдрэгчийг гэмтээж эсвэл буруу заалтын үр дүн харуулж болзошгүй. Та мэдрэгчийг зүүж байхдаа 2.5 метрийн гүнд 2 цаг хүртэл сэлж болно (IP28). Гүн эсвэл хугацаа хэтрүүлэх нь мэдрэгчийг гэмтээж эсвэл заалтын буруу үр дүнд хүргэж болзошгүй.
- Мэдрэгчийн элэгдэлтэй холбоотой харшлын урвал, дунд зэргийн болон хүнд хэлбэрийн загатналт, тууралт, улайлт, хаван, хатуурал, цус алдалт, оруулах хэсгийн шинж тэмдэг, хөхрөлт, өвдөлт, оруулах хэсэг дэх бага зэргийн халдвар, оруулах явцад таагүй байдал мэдрэгдэх зэрэг хөнгөнөөс хүнд урвалууд.
- Гипергликеми эсвэл гипогликеми iCan i3 CGM-ийг хэрэглэх заавар, бүх заалт, эсрэг заалт, анхааруулга, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сэрэмжлүүлгийн дагуу хэрэглэхгүй байх нь хүнд хэлбэрийн гипогликеми (цусан дахь сахарын хэмжээ багасах) эсвэл гипергликемийг (цусан дахь сахарын хэмжээ ихсэх) мэдээлэхгүй байхад хүргэж болзошгүй.
- CGM системийг дутуу эсвэл буруу хэрэглэсэн CGM систем хэрэглэгчдэд хэрэглэх ихээхэн хэмжээний өгөгдөл, мэдээлэл өгдөг. Зааврыг сайтар уншиж, CGM системийн чадавхийг бүрэн ашиглах, чихрийн шижингийн менежмент, эмчилгээний тусгай төлөвлөгөө боловсруулахад тань туслах HCP-тэй хамтран ажиллана уу.

2-р хэсэг: Мэдрэгчээ ажиллуулж ЭХЛЭХ

- Мэдрэгч бэлтгэх
- Хэсэг сонгох
- Мэдрэгчээ дамжуулагчтай холбох
- Мэдрэгч хэрэглэх
- Мэдрэгч халаах

2.1 Мэдрэгч бэлтгэх

2.1.1 Эхлэхээсээ өмнө танд хэрэгтэй бүх зүйл байгаа эсэхийг шалгаарай.

iCan i3 CGM систем:

- Мэдрэгчийн багц
 - Мэдрэгчийн багц дээрх дуусах хугацааг шалгана уу. Хугацаа нь дууссан бол хэрэглэж болохгүй.
 - Мэдрэгчийг оруулахад бэлэн болтол ариутгасан мэдрэгчийн сав баглааг нээж болохгүй
- Дамжуулагчийн багц
 - Мэдрэгчийн багц, дамжуулагчийн багц дээрх SN (серийн дугаар) кодын эхний 8 орон ижил байгаа эсэхийг шалгана уу
- Түргэн эхлэх гарын авлага
- Спирттэй хөвөн
- Таны цусан дахь сахар хэмжигч

iCan i3 CGM системтэй танилцах:

Та CGM-ийг шинээр хэрэглэж байгаа эсвэл туршлагатай эсэхээс үл хамааран хэрэглэхээсээ өмнө Түргэн эхлэх гарын авлагыг уншиж, APP доторх зааварчилгааг бөглөх ёстой.

Хэрэглэгчид тавигдах шаардлага: iCan i3 CGM Хэрэглэх заавар, Түргэн эхлэх гарын авлагыг уншиж, ойлгож, дагаж мөрдөх боломжтой насанд хүрсэн чихрийн шижин өвчтэй хүмүүс тус төхөөрөмжийг аюулгүй хэрэглэж болно.

2.1.2 APP суулгах, тохируулах

Алхам 1: APP тохируулах

APP-ийг нээхийн тулд CGM APP дээр товшино уу.



Алхам 2: Мэдэгдэл, байршилд нэвтрэхийг идэвхжүүлэх

Bluetooth, Байршилд нэвтрэхийг идэвхжүүлэхийн тулд "Зөвшөөрөх" гэснийг товшоод, хөдөлгөөнт төхөөрөмж дээрээ мэдэгдэл хүлээн авахыг зөвшөөрөх бөгөөд ингэснээр та Bluetooth үйлчилгээний дохиоллыг алдахгүй харж эсвэл хэрэглэхээс татгалзахгүй.



WLAN (Утасгүй
дотоод сүлжээ)



Үүрэн сүлжээ



Дуугүй



Байршил



Bluetooth

WLAN/Үүрэн сүлжээ: Та өөртөө бүртгэл үүсгэх ба/эсвэл нэвтрэх, мэдээлэл хуваалцах, бүтээгдэхүүний зааварчилгаа үзэх гэх мэт үед интернет холболттой байх шаардлагатай.

Дуугүй: Хэрэв та дуугүй горимыг ашиглавал бүх дохиолол дуугарахгүй эсвэл чичрэхгүй боловч зүгээр л харуулна.

Байршил: Bluetooth хэрэглэхийн тулд APP таны төхөөрөмжийн байршилд нэвтрэхийг хүсэж болно. Зөвшөөрөх гэснийг товшино уу.

Bluetooth: Энэ APP CGM дамжуулагчтай холбогдохын тулд Bluetooth ашигладаг. Bluetooth-ийг асаасан эсэхээ шалгаарай, эс бөгөөс танд дохиолол эсвэл CGM мэдээлэл ирэхгүй.

Санал болгосон гар утасны төхөөрөмжийн тохиргоо

Тохиргоог хэрхэн өөрчлөх талаар харахын тулд гар утасны төхөөрөмжийн зааварчилгааг харна уу.

CGM системдээ дараах зүйлийг ашиглана уу:

- Bluetooth асаалттай байх: Таны дамжуулагч болон APP Bluetooth-ээр холбогдоно.
Хэрэв асаагаагүй бол та дохиолол, CGM-ийн үр дүн хүлээж авахгүй.
- Мэдэгдэл асаах:
 - CGM APP-ын мэдэгдлийг идэвхжүүлснээр та дохиолол хүлээн авах боломжтой.
 - Та CGM APP-ын мэдэгдлүүдийг таны түгжигдсэн дэлгэц дээр түгжээтэй дэлгэц.
- Батерей цэнэгтэй байх: APP үргэлж арын дэвсгэр дээр ажиллаж байх ёстой бөгөөд таны батарейг дуусгаж болзошгүй. Батарейг цэнэглэж байгаарай. Хэрэв CGM APP арын дэвсгэрт унтарсан бол танд дохиолол ирэхгүй.
- Төхөөрөмж, APP асаалттай байх: Хэрэв та хөдөлгөөнт төхөөрөмжөө дахин асаавал CGM APP-ыг дахин нээнэ үү.
- Дуу, дохиоллын функцийг асааж, төхөөрөмж "Бүү саад бол" горимд байгаа эсэхийг шалгаарай. Хэрэв та төхөөрөмжийн дууг хаасан бол яаралтай анхаарах бага хэмжээ гэх мэт мэдэгдлийн дууг сонсохгүй.
- Ухаалаг утасны дууг хангалттай чанга байлгах: Та дохиоллын дууг сонсож чадах эсэхийг шалгаарай.

- Ухаалаг утас, дамжуулагч хоорондын холболтыг сайн байлгахын тулд дамжуулагч, ухаалаг утасны хоорондын зай 6 метрээс бага байх ёстой.
- Гараар шинэчлэх: таны төхөөрөмжийн үйлдлийн систем тохиргоог өөрчлөх эсвэл APP-ыг унтраах боломжтой. Үргэлж гараар шинэчилж, дараа нь төхөөрөмжийн зөв тохиргоог шалгана уу.
- Тохирох байдал: CGM APP-аар ажилладаг хөдөлгөөнт төхөөрөмж, үйлдлийн системийн жагсаалтыг iCan-cgm.com вебсайтаас шалгана уу.
- Цаг: Хэрэв та янз бүрийн цагийн бүсэд байгаа бол ухаалаг төхөөрөмжийнхөө цагийг гараар сольж болохгүй. Ухаалаг утсандаа цагийг автоматаар солихыг зөвшөөрөхийн тулд сүүлийн очих газраа очих хүртэл хүлээнэ үү. CGM APP үргэлжилж буй үзлэгийн бүх сахарын заалтыг тухайн цагийн бүс дэх шинжилгээний цагтай хамт харуулдаг болохыг анхаарна уу.

Алхам 3: Нэвтрэх

Хэрэв та iCan Health CGM APP-ын шинэ хэрэглэгч бол дэлгэц дээрх зааврыг дагаж, шинэ iCan бүртгэл үүсгэх хэрэгтэй.

Хэрэв та аль хэдийн бүртгэлтэй бол одоо байгаа хэрэглэгчийн нэр, нууц үгээ оруулна уу.

Алхам 4: Хяналтын заавар

Дараа нь Апп-аас таныг iCan систем хэрэглэх талаарх зааварчилгааны видео зэрэг аюулгүй байдлын заавартай танилцахыг хүснэ.

Тэмдэглэл: iCan системийн энэ APP доторх тойм энэхүү Хэрэглэх зааврыг орлохгүй. CGM APP-ыг хэрэглэхээсээ өмнө энэ зааварт байгаа бүх мэдээллийг уншина уу.

2.1.3 Системийн тохиргоо

"Системийн Тохиргоо" товчлуурын доор байрлах "Тохиргоо" бол та нууц үг, имэйл гэх мэт бүртгэлийнхээ профайлыг өөрчлөх боломжтой хэсэг юм.

APP-д хэрэглэсэн сахарын хэмжилтийн нэгжийг өөрчлөх (мг/дл эсвэл ммоль/л)

"Системийн тохиргоо" товчлуурыг товшоод, "Хэмжих нэгж" хэсгийг сонгоно уу.

Хэрэв та өгөгдмөл тохиргооноос өөр хэмжих нэгж хэрэглэхээр шийдсэн бол хэмжих нэгж өөрчлөгдсөнийг баталгаажуулах мессеж олж харна.

Имэйл солих

Таны имэйл хаягийг таныг бүртгэлдээ нэвтрэх, мөн CGM-ийн талаарх чухал мэдээлэл авахад хэрэглэдэг.

APP дотор "Системийн тохиргоо" товчлуурыг товшоод, "Имэйл хаяг өөрчлөх" гэснийг сонгоно уу. Хэрэглэхийг хүссэн шинэ имэйл хаягаа оруулаад, "Дараах" дээр дарна уу.

Та шинэ имэйл хаягаараа баталгаажуулах код хүлээн авна, түүнийг бичээд "Баталгаажуулах" дээр дарна уу.

Нууц үгээ солих

Сайн нууц үг таны мэдээллийг аюулгүй байлгахад чухал үүрэгтэй. Нууц үгээ хааяа өөрчлөхийг зөвлөж байна, ялангуяа таны нууц үг алдагдсан байж магадгүй гэж үзэж байгаа бол өөрчилнө үү.

APP доторх "Системийн тохиргоо" товчлуурыг товшоод, "Нууц үг солих" гэснийг сонгоно уу.

Нэвтрэхдээ хэрэглэдэг имэйл хаягаа оруулаад, "Илгээх" дээр товшвол, танд баталгаажуулах код илгээнэ.

"**ДАРААХ**" дээр товшоод, шинэ нууц үгээ оруулна уу.


Мэдээлэл өгөх зөвшөөрөл

Мэдээлэл өгөх зөвшөөрлийг хянаж, засварлана уу. APP дотор "**Системийн тохиргоо**" товчлуурыг товшоод, "**Мэдээлэл өгөх зөвшөөрөл**" гэснийг сонгоно уу.

Та APP-д өгсөн зөвшөөрлөө эндээс удирдах боломжтой. Мөн та түүхийн мэдээллийг сэргээх, хуваалцах, багцлах, устгах боломжтой.

2.2 Хэсэг сонгох

Мэдрэгчдээ тав тухтай, үр дүнтэй газрыг хэсэг сонгох нь чухал. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэйгээ (HCP) мэдрэгч оруулах хамгийн тохиромжтой эхсгүүдийн талаар ярилцаарай.



АНХААРУУЛГА: Бусад хэсгүүдийг сонгож болохгүй. Бусад хэсгүүд эмнэлзүйн хувьд үнэлэгдээгүй тул таны сахар мэдрэгчийн заалтын үр дүн буруу гарч магадгүй.

ЗӨВЛӨГӨӨ:

- Мэдрэгчийг Инсулин шахах тарилгын багц эсвэл тарилгын хэсгээс багадаа 7 см (3 инч) зайд байрлуул.
- Оруулах хэсэг хуурай, цэвэр, мөн тос, үнэртэн, эм хэрэглээгүй байх хэрэгтэй. Хэрэв шаардлагатай бол наалдамхай туузыг найдвартай наалдуулахын тулд тухайн хэсгийн үсийг хус.
- Бүсэлхийн ойролцоо эсвэл сорви, шивээс, цочирсон, ястай хэсгээс зайлсхий. Мэдрэгчийн наалдуулагч таны арьсыг цочроосон бол НСР-тэйгээ холбогдоно уу.
- 2 мэдрэгчийг дараалан нэг хэсэгт хэрэглэж болохгүй.
- Мэдрэгчийг санамсаргүйгээр салахаас зайлсхийхийн тулд булчин болон хувцас, дагалдах хэрэгслээр хязгаарлагдах хэсгүүд, барзгар арьс, сорвитой хэсгүүд, дасгалын үеэр эрчтэй хөдөлгөөнд өртдөг хэсэг, бүс эсвэл бүсэлхийн тойргийн хэсэгт хэрэглэж болохгүй.

Цэвэрлэх:

- Гараа савантай усаар сайтар угаа. Мэдрэгч хэрэглэх хэсгийг сонго. Оруулах хэсгийг спиртээр цэвэрлэ. Тухайн хэсгийг агаарт хатаана.

2.3 Мэдрэгчээ дамжуулагчтай холбох


iCan i3 CGM дамжуулагч APP-тай Bluetooth-ээр холбогддог тул системийг ашиглахаасаа өмнө APP-тай холбогдсон байх ёстой. Мөн энэ үйл явцыг "Холбох" гэж нэрлэдэг.

Алхам 1: APP тохируулах

2.1.2 хэсгийг дагаж, APP-аа тохируулж, утасныхаа Bluetooth асаалттай байгаа эсэхийг шалгана уу. Bluetooth ашиглан тохируулга хийхийн тулд байршилд нэвтрэх эрх өгөх ёстой.

Алхам 2: 8 оронтой SN кодыг шалгах

Мэдрэгчийн багц, дамжуулагчийн багцыг багц хэлбэрээр савласан бөгөөд серийн дугаарын (SN) кодын эхний 8 оронтой кодыг хуваалцана. Холбохын өмнө SN кодын эхний 8 оронтой тохирч байгаа эсэхийг шалгана уу.



Алхам 3: SN код сканердах



2.1.2 хэсгийн 4-р алхмын дагуу Мэдрэгчийн багцын шошгон дээр байрлах SN 2D бар кодыг уншуулна уу эсвэл Мэдрэгчийн багц дээр бүрэн SN кодыг гараар бичиж оруулна уу. SN код мэдрэгч, дамжуулагчид дахин давтагдахгүй тул кодыг зөв оруулсан эсэхээ шалгаарай. Хэрэв та буруу код эсвэл өөр мэдрэгчийн багцынхаас өөр код оруулсан бол iCan i3 CGM-ийг ашиглах боломжгүй эсвэл таны сахарын заалтын үр дүн буруу гарч болно.

Алхам 4: Холбох

APP мэдрэгчийг дамжуулагч руу хэрхэн холбох талаар зааварчилна. Та CGM системдээ хэрэглэхийн тулд доорх APP-ын зааврыг дагаж болно. Холболт автоматаар эхэлнэ.

2.4 Мэдрэгчийг хэрэглэх

Мэдрэгчийг шалгагч Мэдрэгч-Аппликатор дотор байна. Мэдрэгчийг хэрэглэхээс өмнө Мэдрэгч-Аппликаторын талаар мэдэж аваарай.



Алхам 1: Мэдрэгчийн багцыг нээх



2.3 хэсгээс хэрэглэсэн мэдрэгчийн багцыг аваарай. Сав баглаа нь эвдэрсэн, гэмтсэн, нээгдсэн тохиолдолд битгий хэрэглээрэй. Мэдрэгчийг хэрэглэхэд бэлэн болтол багцыг нээж болохгүй.

АНХААРУУЛГА: Мэдрэгч-Аппликатор зүүтэй байдаг. Мэдрэгч-Аппликаторын дотор талд хүрч эсвэл Мэдрэгчийн багц руу буцааж хийж болохгүй.

Алхам 2: Мэдрэгч хэрэглэх

- Мэдрэгч-Аппликатор дээрх цэнхэр сумтай тэмдгийг Дамжуулагчийн тавиур дээрх тохирох цэнхэр сумтай тэмдэгтэй зэрэгцүүлнэ. Хатуу гадаргуу дээр зогсох хүртэл удаан дарахад тас хийх чимээ сонсогдоно.



- Аюулгүй байдлын унтраалгыг "Түгжигдсэн дүрс"  -ээс "Түгжээгүй дүрс"  рүү зөөлөн эргүүлэхэд тас хийх чимээ сонсогдоно.



СЭРЭМЖЛҮҮЛЭГ: Хүсээгүй үр дүн эсвэл гэмтэл гарахаас сэргийлэхийн тулд Аюулгүй байдлын унтраалга бүрэн сулрах хүртэл дунд хэсэгт байрлах цагаан товчлуурыг дарж болохгүй

- Мэдрэгч-Аппликаторыг дамжуулагчийн тавиураас өргөж ав.




- Одоо мэдрэгчийг хэрэглэхэд бэлэн боллоо.




Алхам 3: Мэдрэгчийн аппликаторыг оруулах


- Мэдрэгчийн аппликаторыг бэлтгэсэн хэсэгт байрлуулж, доош нь удаанаар дар.



- CGM мэдрэгчийг хэрэглэхийн тулд голд байгаа товчлуурыг дарна уу. Та тас хийх чимээг сонсох бөгөөд энэ нь оруулж дууссан гэсэн үг юм.




- Аппликаторыг биеэсээ зөөлөн татаж ав.



СЭРЭМЖЛҮҮЛЭГ: Хэрэглэсэн аппликаторыг орон нутгийн дүрэм журмын дагуу устгана уу.

- Мэдрэгчийг бүтэн элэгдэх хүртэлх хугацаанд биед байлгахын тулд мэдрэгчийн наалдамхай туузыг хуруугаараа тэгшлээрэй.



СЭРЭМЖЛҮҮЛЭГ: Оруулсны дараа мэдрэгчид 2.5 метр хүртэл ус нэвтрэхгүй боловч ухаалаг утас тийм биш байж болно. Хэрэв та усанд эсвэл усны ойролцоо байгаа бол мэдрэгчийн заалтыг авахын тулд дэлгэцийн төхөөрөмжийг ойр (6 метрээс бага) байлгах хэрэгтэй. Хэрэв мэдрэгч усан доор байгаа бол та уснаас гарах хүртэл мэдрэгчийн заалтыг авах боломжгүй байж магадгүй.

2.5 Мэдрэгч халаах

Мэдрэгчээ оруулсны дараа дамжуулагч таны iCan Health CGM APP-тай автоматаар холбогдоно. Мэдрэгчийг 2 цаг халаах хугацаа эхлүүлэхийн тулд та **"Мэдрэгч ажиллуулж эхлэх"** дээр дарах хэрэгтэй.

Та халаах хугацаанд дохиолол эсвэл CGM-ийн заалтын үр дүн хүлээж авахгүй. Таны анхны заалтын үр дүн мэдрэгчийг 2 цагийн халааж дууссаны дараа гарч эхэлнэ. Мэдрэгчийг халаах үед шаардлагатай бол цусан дахь сахар хэмжигчээ хэрэглэнэ үү.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ: CGM мэдрэгч, хөдөлгөөнт төхөөрөмжөө 6 метрийн зайд ямар ч саадгүй (жишээлбэл, хана эсвэл металл) байрлуул. Эс бөгөөс тэд харилцах боломжгүй болно. Хэрэв таны мэдрэгч, хөдөлгөөнт төхөөрөмжийн хооронд ус байвал, жишээлбэл, та шүршүүрт орох эсвэл усанд сэлэх гэж байгаа бол – тэдгээрийг хооронд нь ойр байлгаарай. Bluetooth усанд сайн ажилладаггүй тул хамрах хүрээ нь багасна.

3-р хэсэг: iCan i3 CGM-ийн үр дүн

- Үндсэн дэлгэцийн тойм
- Сахарын мэдээлэл
- Чиглүүлэх ба төлөвийн самбар
- Үйл явдал
- Дохиолол


3.1 Үндсэн дэлгэцийн тойм

Доорх нүүр дэлгэцийг iOS APP-аас авсан бөгөөд Android APP төстэй харагддаг.



Сахарын хэмжээний график

Таны одоогийн ба хадгалагдсан сахарын хэмжээний үзүүлэлтүүдийн график



3.2 Сахарын хэмжээний мэдээлэл



① Сахар мэдрэгчийн заалтын үр дүн

Дээд талаас эхлэн харахад тоо таны мэдрэгчийн сахарын хэмжээ одоо ямар байгааг децилитрт миллиграмм (мг/дл)-ээр харуулна. Сахарын хэмжээний графикийн дэвсгэр өнгө шар, ногоон, улбар шар, улаан байж болно, энэ нь:

200 мг/дл (11,1 ммоль/л) Шар: Сахарын өндөр түвшнөөс дээш (200 мг/дл-ээр урьдчилан тохируулсан)

175 мг/дл (9,7 ммоль/л) Хар: Зорилтот хамрах хүрээнд

69 мг/дл (3,8 ммоль/л) Улбар шар: Сахарын бага түвшнээс доош (70 мг/дл)

55 мг/дл (3,1 ммоль/л) Улаан: Гипогликемийн дохиолол (55 мг/дл-ээр тохируулсан)

Таны CGM-ийн заалтын хамгийн сүүлийн үр дүн 450 мг/дл (25,0 ммоль/ л)-ээс дээш эсвэл 36 мг/дл (2,0 ммоль/л)-ээс доош байвал танд тоо харагдахгүй. Оронд нь таны дэлгэцийн төхөөрөмж БАГА (Бага) эсвэл ӨНДӨР (Өндөр) гэж харуулна. Хэрэв танд тоо харагдахгүй байвал сахараа хэмжихийн тулд цусан дахь сахар хэмжигчээ хэрэглэнэ үү. Эдгээр БАГА эсвэл ӨНДӨР гэсэн заалт таны өөрчлөлтийн график дээр хоосон талбар хэлбэрээр харагдана.



② Өөрчлөлтийн сум

Өөрчлөлтийн сумнууд таны CGM-ийн заалтын сүүлийн үр дүнд тулгуурлан таны сахарын өөрчлөлтийн хурд, чиглэлийг харуулдаг. Хэт өндөр эсвэл хэт бага болохоос өмнө ямар арга хэмжээ авахыг мэдэхийн тулд сумнуудыг хэрэглэнэ үү.

Өөрчлөлтийн сум: Тогтвортой →

Сахар өөрчлөгдөж байгаа боловч 3 минут тутамд 3 мг/дл (0,16 ммоль/л)-ээс бага байна.

Өөрчлөлтийн сум: Аажмаар өсөх эсвэл багасах ↗ ↘

Сахарын хэмжээ аажмаар, 3 минут тутамд 3 мг/дл (0,16 ммоль/л) эсвэл 6 мг/дл (0,33 ммоль/л) хүртэл өөрчлөгдөнө.

Өөрчлөлтийн сум: Хурдан өсөх эсвэл багасах ↗ ↘

Сахарын хэмжээ хурдан өөрчлөгдөж, 3 минут тутамд 6 мг/дл (0,33 ммоль/л) эсвэл 9 мг/дл (0,5 ммоль/л) хүртэл нэмэгдэнэ.


Өөрчлөлтийн сум: Хурдан өсөх эсвэл багасах ↑ ↓

Сахарын хэмжээ хурдан өөрчлөгдөж, 3 минут тутамд 9 мг/дл (0,5 ммоль/л)-ээс их байна.

③ Өөрчлөлтийн график

Доорх график таны CGM-ийн заалтын үр дүн сүүлийн хэдэн цагийн турш ямар байгааг харуулна. Энэ нь таны CGM-ийн заалтын үр дүнг 3 минут тутамд гаргана. CGM-ийн заалтын хамгийн сүүлийн үр дүн бол баруун талд байгаа хар цэг юм. Дунд хэсэгт байгаа цагаан хөндий цэг бол таны сонгосон хугацаан дахь сахарын түвшин юм (жишээлбэл, доорх зурган дээрх 143 мг/дл (7,9 ммоль/л) бол 14:00 цагийн сахарын заалтын үр дүн юм). Зүүн талд байгаа тоонууд сахарын түвшинг мг/дл (ммоль/л)-ээр харуулдаг. Зүүн талд байгаа тоонууд сахарын түвшинг мг/дл (ммоль/л)-ээр харуулна. Доод талд байгаа тоонууд цагийг харуулна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ: Хэрэв та янз бүрийн цагийн бүсийг гаталж байгаа бол CGM APP үргэлжилж буй үзлэгийн бүх сахарын заалтыг тухайн цагийн бүс дэх шинжилгээний цагтай хамт харуулна.




Хэвтээ шугамууд таны Өндөр болон Бага дохиоллын түвшинг харуулна. Таны сахар дараах байдалтай байна:

- Таны цэгүүд графикайн шар хэсэгт байх үед өндөр байна.
- Ногоон хэсэгт байх үед таны зорилтот хамрах хүрээнд (таны өндөр, бага хэмжээний дохиоллын тохиргоо хооронд)
- Улаан хэсэгт байх үед бага байна.


Дохио алдагдах эсвэл үүнтэй төстэй асуудал гарсны дараа дамжуулагч дэлгэцийн төхөөрөмжтэй дахин холбогдох үед 360 цаг хүртэлх CGM-ийн заалтын дутуу үр дүнг график дээр бөглөх боломжтой.

Графикаараа үйл явдлыг харж, 24 цагийн турш графикаа харахын тулд гар утсаа хажуу тийш нь эргүүлээрэй (ландшафтын харагдах байдлын хувьд). CGM-ийн өмнөх заалтын үр дүнг харахын тулд цэг дээр дарж, эсвэл бусад хугацааны CGM-ийн заалтын үр дүнг харахын тулд хуруугаа дэлгэц дээгүүр гулсуулна уу. APP дээрээ үзэх өөр өдрүүдийн хооронд сэлгэхийн тулд ландшафтын харагдах цэсний "Олон хоног" дээр товшино уу. Цагаан дугуй цэг 1 өдрийн дотор сонгосон үр дүнг харуулах бөгөөд сахарын заалтын үр дүн зүүн дээд самбар дээр харагдана.



④ Өдөр тутмын дундаж хэмжээ

APP таны CGM-ийн мэдээллийн өөрчлөлтийг 15 хоногоор нэгтгэн 1 өдрийн сегментээр харуулдаг. Цагаан дугуй цэг таны дээд самбараас харж буй сонгосон өдөр тутмын тоймыг заана.




- A. Сахарын дундаж хэмжээ бол сонгосон огнооноос таны CGM-ийн бүх сахарын заалтын үр дүнгийн дундаж хэмжээ юм. Таны сахарын дундаж хэмжээг мэдэх нь таны тоог зорилтот түвшинд хүргэхийг оролдож эхлэхэд тохиромжтой хэсэг юм.
- B. Хамгийн өндөр/Хамгийн бага хэмжээ таны сахарын түвшин хамгийн өндөр ба хамгийн бага түвшинд хүрэх хугацааг заана.
- C. Хамрах хүрээнд дээш хугацаа (TIR) бол таны сахарын түвшин зорилтот хэмжээнд байх хугацааны хувь юм. CGM APP-ын өгөгдмөл зорилтот хүрээ 70-200 мг/дл (3,9-11,1 ммоль/л) бөгөөд энэ нь таны CGM-ийн тохируулсан хэмжээ биш байж болно. Та Тохиргоо дотроос хамрах хүрээг өөрчлөх боломжтой.
- D. Хамрах хүрээнд доош хугацаа (TAR) таны сахарын түвшин зорилтот хамрах хүрээнд доош хугацааны хувь юм. CGM APP-ын өгөгдмөл өндөр хамрах хүрээ 200 мг/дл (11,1 ммоль/л)-ээс дээш байна.

Е. Хамрах хүрээнээс бага байх хугацаа (TBR) таны сахарын түвшин зорилтот хязгаараас бага байх хугацааны хувь юм. CGM APP-ын өгөгдмөл бага хамрах хязгаар 70 мг/дл(3,9 ммоль/л)-ээс бага байна.

⑤ Харьцуулалт

CGM APP танд өмнөх хяналтаас дурын 2 өдрийг сонгож, хяналтын үр дүнг харьцуулах боломж олгодог. График дээрх өнгөт шугам таны сонгосон огноонуудыг (дээд самбарын баруун талд), цагаан дугуй цэг сахарын түвшинг тодорхой хугацаанд (дээд самбарын зүүн талд) илэрхийлнэ.



3.3 Чиглүүлэх ба төлөвийн самбар

Тус APP сахарын хэмжээний тойм тайлан, үйл явдлын түүх үзэх, мэдрэгч оруулах заавар, хэрэглэх талаарх бүрэн заавар зэрэг хэрэгтэй мэдээллийг олох боломжтой хэсгүүдээс бүрдэнэ.

3.3.1 Сахарын хэмжээний тойм тайлан

Сахарын хэмжээний тойм тайлан танд сүүлийн 15 хоног хүртэлх өмнөх сахарын хэмжээний мэдээллийн тайлан үүсгэж, хуваалцах боломж олгоно.

- APP дотор доод талын төлөвийн самбар дээрх "Үйл явдал" товчлуурыг дарна уу.
- "Түүхийн тайлан" дээр товшоод, үзэхийг хүссэн огнооны хамрах хүрээгээ сонгоно уу.
- Та "Үйл явдлын түүх" дээр товшоод, бүх дохиоллын мэдээллийг хянах боломжтой.
- "ХУВААЛЦАХ" гэснийг дарж, тайлангаа хуваалцахыг хүссэн хүндээ имэйлээр илгээнэ үү.

3.3.2 Тусламжийн гарын авлага

"Тусламж" хэсэгт "Түргэн эхлэх гарын авлага", "Бүтээгдэхүүний заавар", "Хэрэглэх заавар", төхөөрөмжийн бусад мэдээлэл зэрэг iCan i3 CGM системийн хэрэглэгчийн зааврын дижитал хувилбар багтсан.


3.4 Үйл явдал

Үйл явдал бол таны сахарын түвшинд нөлөөлдөг үйлдэл эсвэл нөхцөл байдал юм. iCan i3 CGM системийн тусламжтайгаар та өдөр тутмын үйл явдлуудаа хянах боломжтой, ингэснээр та тэдхээрийн сахарын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөг оруулах боломжтой. APP-д орсны дараа үйл явдлуудыг үндсэн дэлгэц болон тайлангаас харах боломжтой. Тайлангууд үйл явдал бүр таны сахарын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлсөнийг хянахад тусална. Та эрүүл мэндийн мэргэжилтэнтэйгээ (HCP) хамт тайланг хянаж, чихрийн шижингийн эмчилгээгээ удирдах төлөвлөгөө гаргах боломжтой.

3.4.1 Инсулины хэрэглээ оруулах

Алхам 1: Үндсэн дэлгэцээс "+" дээр товш

Алхам 2: Дараа нь инсулины хажууд байгаа "Үйл явдал нэмэх" дээр товш



Алхам 3: Инсулины төрөл сонгох

Та эндээс инсулины төрөл сонгох боломжтой - Хурдан үйлчилдэг, Амьсгалаар хурдан үйлчилдэг, Тогтмол/богино хугацаанд үйлчилдэг, Дунд хугацаанд үйлчилдэг, Урт хугацаанд үйлчилдэг, Хэт удаан үйлчилдэг эсвэл Урьдчилан хольсон.

Алхам 4: Тун тус бүрд инсулины нэгжийг 99 нэгж хүртэл оруулна уу.

3.4.2 Бусад үйл явдал

Та АРР дээрээ инсулинаас гадна хоолны дэглэм, дасгал, эмийн эмчилгээ, бусад арга хэмжээг нэмэх боломжтой. Эдгээр үйл явдлыг нэмэх нь инсулин нэмэхтэй маш төстэй.

Танд тухтай болгох үүднээс бүх зүйлийг зогсоож, үйл явдлуудаа болж байгаа байдлаар нь оруулах хэрэггүй. Танд цаг гарвал өнгөрсөн үйл явдлуудыг оруулж болно. Үйл явдлуудыг тус тусад нь оруулах зорилготой.

3.5 Дохиолол

Таны CGM-ийн заалтын үр дүн таны зорилтот хүрээнээс урьдчилан тогтоосон дохиоллын түвшинд шилжих үед Таны хөдөлгөөнт төхөөрөмж дохиолол, таны хөдөлгөөнт төхөөрөмжөөс хамааран харах мэдэгдэл, чичиргээ эсвэл дуут дохиогоор танд мэдэгдэнэ. Та сахартай холбоотой дохиоллыг баталгаажуулах хүртэл 3 минут тутамд танд мэдэгдэл, чичиргээтэй дохиоллын дэлгэц харагдана. Таныг зорилтот хамрах хүрээндээ буцаж ирэх хүртэл дохиоллын мэдээлэл таны үндсэн дэлгэц дээр байна.

АРР-ыг хэрэглэхээсээ өмнө F хавсралтын дохиоллын чичиргээ болон дохиоллын дууны хэсэгт орж, манай iPhone, Android утасны тохиргооны зөвлөмжийг шалгана уу.

Мөн НСР-тэйгээ дохиоллын тохиргооны талаар ярилцаарай. Тэд тэдгээрийг өөр утгуудаар өөрчлөхийг санал болгож болно.

3.5.1 Дуугүй горим

Яаралтай анхаарах бага хэмжээний дохиоллын үед (сахарын үр дүн (\leq) 55 мг/дл буюу 3,1 ммоль/л-ээс бага) эсвэл сахарын хэмжээ хурдан өөрчлөгдөж байгаа үед (дээд зорилтот хязгаарт болон глюкозын түвшин хурдан өсөх/доод зорилтот хязгаар дотор, глюкозын түвшин хурдан буурах) урт чичиргээгээр тогтсон дуут дохио өгөх ба хяналтын хуудсан дээр гарч попап цонх гарч ирнэ. Хэрэглэгч үүнийг гараар баталгаажуулж, хаах хэрэгтэй; дараа нь та хэсэг хугацаанд сануулахгүй байхыг сонгож болно. Сонгосны дараа та цагийн үргэлжлэх хугацааг (0,5-6 цаг, дотоод 0,5 цаг) сонгож болно. Энэ попап цонхонд холбогдох эрсдэлийг баталгаажуулсны дараа ① дуугүй байдал нүүр хуудасны баннер дээр гарч ирэх ба үүнийг хүссэн үедээ хааж болно. Үүнийг попап цонхонд баталгаажуулахын тулд сонгоно уу; ② мөн хөвөгч цонх эсвэл мэдэгдлийн талбар (функцийг идэвхжүүлсэн үед) дуугүй горим, урвуу тоолохыг харуулах хэрэгтэй. APP-д нэвтрэхийн тулд үүнийг сонгоод, хаах сонголтыг баталгаажуулах попап цонх гарч ирнэ.

3.5.2 Дохиолол

Дохиолол бол таны сахарын хэмжээний өөрчлөлтийн түвшин эсвэл анхаарал хандуулах хэрэгтэй CGM системийг танд мэдэгдэх мессеж юм. Та APP-ынхаа дохиоллыг өөрчлөх боломжтой.

Таны хөдөлгөөнт төхөөрөмжийн дууг асаалттай үед энэ нь чичирч, дохиоллын дуу гаргадаг. Шаардлагатай тохиолдолд та дохиоллын дуу эсвэл чичиргээг унтрааж болно.

CGM системээ ашиглан эмчилгээний шийдвэр гаргахдаа төхөөрөмжийнхөө дууг хаахгүй, чанга яригч ажилладаг байлгах нь дээр.

АНХААРУУЛГА: Хэрэв та чихэвч хэрэглэдэг бол дохиолол таны ухаалаг төхөөрөмжийн чанга яригч дээр биш зөвхөн чихэвчээр сонсогдоно. Хэрэв таны төхөөрөмжийн дууг чангалаагүй, дууг нь хаасан эсвэл чихэвч залгасан бол та яаралтай анхаарах бага хэмжээний дохиолол гэх мэт мэдэгдлийн дууг сонсохгүй.

Бага хэмжээ заасан дохиолол

Таны CGM-ийн заалтын үр дүн таны тогтоосон сахарын зорилтот хамрах хүрээнээс бага байвал танд "Бага хэмжээ заасан дохиолол" сонсогдоно. Та юу сонсож, мэдэрч, харах вэ:

- Сахарын түвшин зорилтот доод хязгаарт хүрэх үед 6 чичиргээ, 6 дуут дохио дуугарна;
- Сахарын түвшин зорилтот доод хязгаар дотор, тогтвортой байх үед 3 минут тутамд 2 чичиргээ, 2 дуут дохиолол дуугарна;
- Сахарын түвшин зорилтот доод хязгаар дотор, аажмаар буурах үед 3 минут тутамд 3 чичиргээ, 3 дуут дохио дуугарна;
- Сахарын түвшин зорилтот доод хязгаар дотор, хурдацтай буурч байх үед 3 минут тутамд 6 удаа чичиргээ, 6 дуут дохио дуугарна;
- Сахарын түвшин зорилтот доод хязгаар дотор, хурдацтай буурч байгаа үед хэрэглэгч попап цонхтой тогтмол чичиргээ, дуут дохиолол дуугарна.

Өндөр хэмжээ заасан дохиолол

Энэ нь таны CGM-ийн үр дүн таны зорилтот сахарын зорилтот хамрах хэмжээнээс их үед танд мэдэгдэнэ.

Та юу сонсож, мэдэрч, харах вэ:

- Сахарын түвшин зорилтот дээд хязгаарт хүрсэн үед 6 чичиргээ, 6 дуут дохиолол дуугарна;
- Сахарын түвшин зорилтот дээд хязгаар дотор, тогтвортой байх үед 3 минут тутамд 2 чичиргээ, 2 дуут дохиолол дуугарна;

- Сахарын түвшин зорилтот дээд хязгаар дотор, аажмаар нэмэгдэж байгаа үед 3 минут тутамд 3 удаа чичиргээ, 3 удаа дуут дохиолол дуугарна;
- Сахарын түвшин зорилтот дээд хязгаар дотор, хурдацтай өсөх үед 3 минут тутамд 6 удаа чичиргээ, 6 удаа дуут дохиолол дуугарна;
- Сахарын түвшин зорилтот дээд хязгаар дотор, хурдацтай буурч байгаа үед хэрэглэгч попап цонхтой тогтмол чичиргээ, дуут дохиолол дуугарна.

Bluetooth-ийн холболт тасарсан дохиолол

Энэ нь танд iCan заалтын үр дүн гарахгүй байгаа үед мэдэгдэнэ. Таны хөдөлгөөнт төхөөрөмж дамжуулагчаас хэт хол байх эсвэл дамжуулагч болон дэлгэцийн хооронд хана, ус гэх мэт ямар нэг зүйл байж болзошгүй.

Бусад дохиоллоос ялгаатай нь Bluetooth-ийн холболт тасарсан дохиоллыг унтрааж болохгүй. Та DND горимыг асаах эсвэл Системийн дохиололыг унтрааснаар зөвхөн дууг унтрааж болно. Чичиргээг унтраах боломжгүй тул та дахин холбогдох хүртэл 3 минут тутамд APP-ын мэдэгдэл хүлээж авна.

Энэ асуудлыг засахын тулд дамжуулагч, дэлгэцийн төхөөрөмжийг хоорондоо 6 метрийн зайтай байлга. Хэрэв энэ нь ажиллахгүй бол Bluetooth-ийг унтрааж, асаана уу. Та 10 минут хүлээнэ үү, хэрэв энэ нь ажиллахгүй байвал хөдөлгөөнт төхөөрөмжийг дахин эхлүүлж, CGM APP-ыг дахин нээнэ үү.

Дохио алдагдсан үед сахараа шалгаж, эмчилгээний шийдвэр гаргахын тулд цусан дахь сахар хэмжигчээ хэрэглэнэ үү.

3.5.3 Дохиоллоо тусгайлан тохируулах

Та дохиоллыг хэрхэн тохируулах нь чихрийн шижингийн зохицуулалтын зорилгодоо хүрэхэд тусална. Та болон таны зорилгод хамгийн сайн тохирох дохиоллын тусгай тохируулга хийхийн тулд НСР-тэйгээ хамтран ажиллана уу.

Сахарын дохиоллын өгөгдмөл тохиргоо 200 мг/дл (11,1 ммоль/л) (өндөр) ба 70 мг/дл (3,9 ммоль/л) (бага) байна.

Анхдагч сахарын дохиоллын түвшинг өөрчлөхийн тулд:

- a. Мэдрэгч халаах дэлгэц эсвэл үндсэн дэлгэцийн доод хэсэгт байрлах "Тохиргоо" дээр товшино уу.
- b. "Хувийн тохиргоо"-г сонгоно уу.
- c. Өөрчлөх дохиоллын түвшинг товш.

Бүү саад бол горим

Хэрэв та дуут дохиоллыг хаахыг хүсвэл асаана уу



Надад дээрхийг мэдэгдэнэ үү

200 мг/дл-ээс дээш үед мэдэгдэх

200 мг/дл >

Дуу



Чичиргээ



Доорх зүйлийг надад мэдэгдэнэ үү

70 мг/дл-ээс доош үед мэдэгдэх

70 мг/дл >

Дуу



Чичиргээ



Системийн дохиолол

Цусан дахь сахарын мэдэгдлээс бусад бүх мэдэгдлүүд

Дуу



Хэрэв та энэ дохиоллыг түгжихийг хүсвэл асаана уу


Асаасны дараа та цусан дахь сахарынхаа хэмжээг мэдэгдлийн самбар эсвэл виджетээс шалгаж болно.



Сахарын хэмжээ бага дохиоллын

Сахарын хэмжээ бага дохиолол өгөгдмөл байдлаар асаалттай. Дохиоллын түвшинг өөрчлөхийн тулд товшино уу.

Хэрэв дохиолол асаалттай байвал таны сахарын хэмжээ анх 70 мг/дл (3,9 ммоль/л) болгож тохируулсан хэмжээнээс бага байвал танд мэдэгдэнэ. Энэ утгыг 60 мг/дл (3,3 ммоль/л) ба 100 мг/дл (5,6 ммоль/л) хооронд өөрчлөхийн тулд товшино уу.



